

Цахим бодлого, статистик мэдээллийн газар
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШ Ү
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Сургалтын цахим платформ хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим контент, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх	- Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах - 3,7 тэрбум төгрөг. - Контент боловсруулалт - 490 сая төгрөг.	Цахим сургалтад хамрагдсан хүүхдийн тоо, боловсруулж нийтийн хүртээл болгосон контентын тоо.	-Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар 2023-2024 оны хичээлийн жилд 10-р ангийн 9,028, 11-р ангийн 6,511 сурагч цахим сургуульд суралцаж байна. -"Medle" контентын санд ээлжит хичээл 9,027, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230,	- 2024-2025 оны хичээлийн жилээс ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулна. - "Medle" контентын санд ээлжит хичээлийн контентийн санг 16,000 контенттой болгоно. - ЕБС-ын сурах бичгийн интерактив хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар 2024 оны хагас жилийн байдлаар 475 ерөнхий боловсролын сургуулийн 10-р ангийн 9,028, 11-р ангийн 6,511 сурагч, нийт 15,539 суралцагч цахим сургуульд суралцаж, 152 сургуулийн 282 багш 10-р ангийн 571 бүлэг, 11-р ангийн 453 бүлэг удирдан хичээл зааж байна.	100%	100%	

				Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна.			2024.05.01-ээс 20-ны өдрүүдэд student.medle.mn боловсролын салбарын суралцагчийн системээр хийлгэсэн. Нийт 9,10,11 дүгээр анги /Дараа жил 10-12 дугаар ангид суралцах/-ийн 125,813 суралцагч 429,072 хичээлийг сонгосон байна. Мөн "Medle" контентын санд ээлжит хичээл 10,139, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна.		
1.1.1	Ахлах ангийн сонгон суралцах хичээлийг цахимаар зохион байгуулах ажлыг өргөтгөнө	3,7 тэрбум төгрөг	Цахим сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	2023 оны жилийн эцсийн байдлаар сургуульд бүлэг бүрдээгүйгээс 475 /нийслэл-120, аймгийн төв-125, сум-	2023-2024 оны хичээлийн жилд 10,11-р ангийн сонгон судлах хичээлийг зохион байгуулж, 2024-2025 оны	Ахлах ангийн сонгон суралцах хичээлийг цахимаар зохион байгуулах ажлыг Улсын хэмжээнд 10-12	2023-2024 оны хичээлийн жилд нийт ахлах ангийн сонгон судлах хичээлийн сонголтыг 9-10 дугаар сард БСМС-ийн суралцагчийн удирдлагын	100%	100%

				<p>222, баг-7, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 9,028, 11-р ангийн 6,511 сурагч цахим сургуульд суралцаж байна.</p>	<p>хичээлийн жилд 10-12-р ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна.</p>	<p>дугаар ангид зохион байгуулана.</p>	<p>системээр дамжуулан хийлгэсэн бөгөөд 10-р ангийн 44,619, 11-р ангийн 39,121 сурагч хичээл сонголт хийсэн. Түүнээс бүлэг бүрдээгүй 475 /нийслэл-120, аймгийн төв-125, сум-222, баг-7, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 9,028, 11-р ангийн 6,511 сурагч, нийт 15,539 суралцагч цахим сургуульд суралцаж байна. Эдгээрээс сургууль дээрээ танхимд хяналтын тоонд хүрсэн ч багшийн дутагдал, танхимын хүрэлцээгүйгээс болж 10-р ангийн 643 сурагч, 11-р ангийн 211 сурагч цахимаар суралцаж байна. Энэ хичээлийн жилд 152 сургуулийн /орон нутгийн-98, нийслэл-54/ 282 багш 10-р ангийн-571 бүлэг, 11-р ангийн- 453 бүлэг удирдан хичээл</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							<p>зааж байна. 2024-2025 оны хичээлийн жилд сонгон судлах хөтөлбөрийн 16 хичээлээс 10 дугаар ангийн суралцагчид 4, 11 дүгээр ангийн суралцагчид 3 хичээлийг заавал сонгон судлах бөгөөд тус урьдчилсан хичээл сонголтыг улс орон даяар 2024.05.01-ээс 20-ны өдрүүдэд student.medle.mn боловсролын салбарын суралцагчийн системээр хийлгэсэн. Нийт 9,10,11 дүгээр анги /Дараа жил 10-12 дугаар ангид суралцах/-ийн 125,813 суралцагч 429,072 хичээлийг сонгосон байна.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
1.1.2	Цахим хичээл, контетийн сан бүрдүүлнэ	450 сая төгрөг /БМТТ/	Боловсруулж нийтийн хүртээл болгосон цахим хичээл,	2023 оны жилийн эцсийн байдлаар "Medle" контентын санд ээлжит хичээл	"Medle" контентын санд 1,500 ээлжит хичээл байршуулсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурах бичгийн цахим хэлбэрт	БШУ-ны сайдын 2022 оны "Журам батлах тухай" 123 дугаар тушаалаар ЕБС-н контентын санг бүрдүүлэх	100%	100%

			<p>контентын тоо</p> <p>9,027, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яам</p> <p>Польшийн "Learnetic" боловсролын технологийн компанитай хамтран ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 33 сурах бичгийн бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт бүрэн шилжүүлж дууссан.</p>		<p>бүрэн шилжүүлж, хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн байна.</p>	<p>журам, 2022 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/384 дугаар тушаалаар ЕБС-н хичээлийн контент сонгон шалгаруулах аргачлал тус тус батлагдсан бөгөөд журам, аргачлалын дагуу багш нарын дунд нээлттэй сонгон шалгаруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. 2024 оны хагас жилийн байдлаар "Medle" контентын санд ээлжит хичээл 10,139, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна. Мөн БШУЯ Польшийн "Learnetic" боловсролын технологийн компанитай хамтран ЕБС-ийн</p>	
--	--	--	---	--	--	--	--

						<p>бага ангийн 33 сурах бичгийн бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт бүрэн шилжүүлэх ажил хийгдэж байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.10 дахь заалтад тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор "Хиймэл оюун ухаанд суурилсан багшийн ухаалаг туслах систем"-ийн Болорсофт ХХК-тай хамтран ажиллаж, хөгжүүлэлт хийж хэрэглээнд нэвтрүүлсэн. Багшийн туслах системийг Монгол хэлний хичээлийн заах арга зүйн дата дээр сургасан бөгөөд цаашид үе шаттайгаар бүх хичээлийг нэвтрүүлэх</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						төлөвлөгөөтэй ажиллаж байна. https://edu.egune.com/		
1.2.	Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбох, мэдээллийн нэгдсэн сүлжээг өргөтгөх, нэгж байгууллагын дотоод сүлжээний орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	ЕБС-ын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал 34 тэрбум төгрөг	Дотоод сүлжээний орчин бүрдүүлсэн, дотоод сүлжээний хичээлийн байрын тоо	12,500 багш зөөврийн компьютер, 150 гариу сургууль цахим танхим байгуулах, 712 сургуулийн хичээлийн байранд утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх захиалга өгсөн байна.	Төрийн өмчийн бүх ЕБС нэг цахим танхимтай, нэг хичээлийн байр нь дотоод сүлжээний орчин бүрдүүлсэн байна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын удирдлагын мэдээллийн системээр мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөлт болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ хийх статистик тайлан мэдээг системээр нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлэхээр системийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулсан. Тус системийн байгууллагын нэгтгэлийн модуль тестийн түвшинд, тусгай зөвшөөрөл, хүний нөөц, сургалтын төлөвлөгөөний модулийн хөгжүүлэлт хийгдэж	90%	90%

						<p>байна. 2024 оны хагас жилийн байдлаар 288 сургууль SMS, LMS-ийг, 48 цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд БСМС-тэй мэдээлэл солилцож байна.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалт буюу тендерээр 10666, хосолсон сургалтын Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлсэн төслөөр 250, хандив тусламжаар 1000, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3593, нийт 14337 ширхэг зөөврийн компьютероор багш нарыг бүрэн хангаж ажилласан, 695 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 517</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 274 захиалга өгч гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна.		
1.2.1	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн системийг шинэчилнэ.	-	Системийн шинэчлэгдсэн модулийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/228 дугаар тушаалаар Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, системийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээг хийн хөгжүүлэх	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийн ажлын даалгаварыг боловсруулан, бэлтгэл ажлыг хангасан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлж, туршсан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, хөтөлбөр, төлөвлөгөөний дүрэм журам шинэчлэгдэн батлагдсан, боловсролын салбарын мэдээллийн системүүдтэй уялдаа холбоогүй, бүтэцийн хувьд ялгаатай, өөр программын хэл дээр бичигдсэнтэй холбоотойгоор салбарын систем хооронд мэдээлэл солилцоход хүндрэл учирдаг тул тус системийг шинэчлэх шаардлага үүссэн. Иймд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын	70%	50%

				ажлын даалгаврыг эхний байдлаар боловсруулсан.		22-ны өдөр А/76 дугаар бүхий “Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын удирдлагын мэдээллийн системээр мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөлт болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, дүн шинжилгээ хийх статистик тайлан мэдээг системээр нэгтгэн гаргах боломжийг бүрдүүлэхээр системийн ажлын даалгаврыг	
--	--	--	--	--	--	--	--

						<p>эцэслэн боловсруулсан. Тус ажлын даалгаврын дагуу ерөнхий үйл ажиллагааны процесс, шинэ системийн модулийн суурь судалгааг хийж, системийн цар хүрээний баримт бичгийг боловсруулсан. Тус системийн байгууллагын нэгтгэлийн модуль тестийн түвшинд, тусгай зөвшөөрөл, хүний нөөц, сургалтын төлөвлөгөөний модулийн хөгжүүлэлт хийгдэж байна.</p> <p>Байгууллагын бүртгэл, тусгай зөвшөөрлийн нэгтгэл модулиудыг 2024.07.31, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний бүртгэл, анги бүлэг, суралцагчийн бүртгэл модулиудыг 2024.08.31, хичээл сургалтын агуулга, ирц дүн үнэлгээний</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							бүртгэл, тэтгэлгийн бүртгэлийн модулиудыг 2024.12.31-нд тус тус бүрэн ажиллагаанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
1.2.2	Боловсрол сургалтын байгууллагад сургуулийн удирдлагын болон сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	-	SMS, LMS систем нэвтрүүлсэн сургалтын байгууллагын тоо	2023 оны жилийн эцсийн сайрын байдлаар 381 сургууль SMS, LMS-ийг, 21 цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд БСМС-тэй мэдээлэл солилцож байна.	2023-2024 оны хичээлийн жилд нийт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 50 хувьд SMS, LMS-ийг нэвтрүүлсэн байна.	БСМС-тэй мэдээлэл солилцоно.	БШУ-ны сайдын 2022 оны “Шаардлага батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага /LMS, SMS/”, А/370 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системд тавих шаардлага”-ыг тус тус баталсан. ТХААГ-аас тус шаардлагад нийцүүлэн гүйцэтгэгчийг	100%	90%

						<p>сонгон шалгаруулж, LMS, SMS систем дээр Дижитал Эдү Менежмент ХХК, Гранд Ай Ти ХХК, ЕСМ ХХК, Амжилт Дот Ком ХХК гэсэн 4, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем дээр Дижитал Эдү Менежмент ХХК, Гранд Ай Ти ХХК, Арта Софт Скуул ХХК гэсэн 3 нийт давхардсан тоогоор 5 аж, ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулснаар дээрх системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. 2024 оны хагас жилийн байдлаар 288 сургууль SMS, LMS-ийг, 48</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд БСМС-тэй мэдээлэл солилцож байна. E- Geree.mn цахим гэрээний системийг хөгжүүлэгч "Смарт Контракт Монголиа" ХХК-тай байгуулсан ЦБСХ- 2023/139 дугаартай мэдээлэл солилцох гэрээний дагуу Эдүтэн, Пийрсон хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудтай 100% цахимаар гэрээ байгуулсан байна. 2024-2025 оны хичээлийн жилд суралцах 760,000 орчим суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай суралцах гэрээг байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

							Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн цахим бүртгэл хяналтын library.gerege.mn системийг хөгжлүүлэгч Гэрэгэ эдтек ХХК-тай мөн 2023 онд ЦБСМГ-2023/212 дугаартай мэдээлэл солилцох гэрээ байгуулснаар “Сурах бичгийн цахим бүртгэл, хяналтын систем”-ийг нийт ерөнхий боловсролын сургуулийн 80 хувь буюу 671 сургууль ашиглаж, түүний 67 хувь буюу 448 сургууль сурах бичгийн түрээсийн үйлчилгээг авсан байна.		
1.2.3	Боловсролын сургалтын байгууллагын дотоод сүлжээний орчин бүрдүүлнэ.	Сургуулийн хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал 34 тэрбум төгрөг	Дотоод сүлжээний орчин бүрдүүлсэн сургуулийн тоо	Нийт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 1,118 хичээлийн байрнаас 229 хичээлийн байранд дотоод сүлжээний	Нийт сургуулийн 50 хувьд утасгүй дотоод сүлжээний орчин бүрдсэн байна.	Нийт сургуулийн 70 хувьд утасгүй дотоод сүлжээний орчин бүрдсэн байна.	Боловсролын нэгдсэн сүлжээний дэд бүтцийн хэвийн ажиллагааг чиг үүргийн дагуу БЕГ, БМТТ хяналтын системээр хяналт тавьж, дуудлага авч ажиллаж байгаа бөгөөд 2024 оны хагас жилд нийт 536 эвдрэл	90%	70%

				орчин бүрдүүлсэн байна.		гэмтлийн талаар дуудлага хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Салбарын сүлжээний нийт гарцын ачаалал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 Gbps аас 11 Gbps болж 3.6 дахин өссөн байна. Аймаг, сумын холбооны байр хүртэлх тоон сүлжээний зурвасын өргөнийг техникийн боломжит дээд хэмжээнд нь тултал нь буюу 10 Mbps байсан сумыг сургуулийг 20, 30, 40, 100 Mbps хүртэл, Аймгийн төвийн сургуулийг 1000 Mbps хүртэл нэмэгдүүлсэн. МУЗГ-н 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" 91 дүгээр тогтоол, 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дугаар		
--	--	--	--	-------------------------------	--	---	--	--

						<p>тогтоолоор батлагдсан ЕБС, цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд "Цахим хэрэглээний зардал", "Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалт" гэж тусгагдсан. Утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл арга хэмжээг 24 сарын хугацаанд, цахим танхим байгуулах төсөл арга хэмжээг 48 сарын хугацаанд төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэй ерөнхий гэрээний журмаар зохион байгуулж байгаа бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар байдлаар 697 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 517 сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 263 захиалга өгч гэрээ байгуулж,</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна.		
1.2.4	Багш бүрт компьютер олгож, сургууль бүрт цахим танхим байгуулах боломж олгоно.	13 тэрбум төгрөг	1. Компьютерт ой болсон багш, хувиар 2. Дотоод сүлжээгээ сайжруулах, ухаалаг анги, зурагттай болох захиалга, хувиар	2023-2024 оны хичээлийн жилд - 65%	Компьютероор хангагдсан багш – 100% Дотоод сүлжээгээ сайжруулах, ухаалаг анги, зурагттай болох захиалга – 50% Цахим ангитай политехник коллеж - 5	-	МУЗГ-н 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоол, 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дугаар тогтоолоор батлагдсан ЕБС, цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд “Цахим хэрэглээний зардал”, "Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалт" гэж тусгагдсан. Мөн БШУ-ны сайдын 2022 оны "Заавар батлах тухай" А/170 дугаар тушаалаар зарцуулах заавар батлагдсан. Тус яамнаас бараа, ажил үйлчилгээний техникийн тодорхойлолтыг батлан ТХААГ-т	90%	90%

						<p>хүргүүлж тус байгууллагаас гүйцэтгэгч сонгон шалгаруулах ХАА- ааг зохион байгуулж, гүйцэтгэгч нартай ерөнхий гэрээ байгуулан суурин болон зөөврийн компьютер, Таблет /iOS, андройд/ Ухаалаг самбар зэрэг боловсрол сургалтын зориулалттай тоног төхөөрөмжийг төрийн цахим дэлгүүрт байршуулсан. Багш бүрт зөөврийн компьютер олгох үйл ажиллагааг зохион байгуулж, 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр ЕБС- ын 13017 багш зөөврийн компьютергүй байна гэсэн тооцоо гарсан. Эдгээр багшийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн хүрээнд зөөврийн компьютероор</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>хангах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангасан. Өнөөдрийн байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалт буюу тендерээр 10666, хосолсон сургалтын Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлсэн төслөөр 250, хандив тусламжаар 1000, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3593, нийт 14337 ширхэг зөөврийн компьютероор багш нарыг бүрэн хангаж ажилласан. Мөн утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл арга хэмжээг 24 сарын хугацаанд, цахим танхим байгуулах төсөл арга хэмжээг 48 сарын хугацаанд төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэй ерөнхий гэрээний журмаар зохион байгуулж байгаа бөгөөд 2024 оны</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						хагас байдлаар 695 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 517 сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 274 захиалга өгч гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна.		
1.4.	Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.	-	Цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, лавлагааны санг баяжуулсан мэдээллийн тоо,	2022-2023 оны хичээлийн жилд төгссөн дээд боловсролын 23,314, бүрэн дунд боловсролын 34,263, суурь боловсрол 60,472 иргэний мэдээлэл, 2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй	Дээд боловсролын баримт бичиг бүртгүүлэх хүсэлтийг цахимаар авдаг болно, лавлагааны санг 2023-20234 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжуулна.	2023-2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 145,345, ЕБС-д суралцаж буй 771,722 СӨБ суралцаж буй 274,236, НТБТ-д суралцаж буй 5,095 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөгчдийн мэдээллээр лавлагааны сан баяжиж, 449,747 иргэний дээд	100%	90%

				<p>5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна.</p>		<p>боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна. БШУЯ-аас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1-7.4, 7.10-7.12, 8.20-8.23, 8.2 дугаар зүйлийн 6.2-6.5, 6.14-д заасан энгийн болон тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт ирүүлсэн аж ахуй, нэгж байгууллагын ирүүлсэн баримт бичигт холбогдох хууль журмын шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгаж, шаардлага хангасан хуулийн этгээдэд холбогдох 11 төрлийн тусгай болон 5 төрлийн энгийн зөвшөөрлийг олгож байна. Хагас жилийн хугацаанд www.license.mn тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан нийт 27 байгууллагын</p>	
--	--	--	--	---	--	---	--

							тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичигт магадлан шалгах ажиллагааг хийж, 19 байгууллагад зөвшөөрөл олгосон байна. 1 байгууллагад тусгай зөвшөөрөл олгох боломжгүй болохыг системээр дамжуулан мэдэгдсэн.		
1.4.1	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний санг баяжуулж, боловсролын салбарын төрийн цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.	-	Лавлагааны санг баяжуулсан тоо, Цахимаар үйлчилгээ үзүүлсэн тоо, Нэмэгдсэн үйлчилгээний тоо	2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй 5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж	Лавлагаа тодорхойлолтын сан 2023-2024 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	Лавлагаа тодорхойлолтын сан 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	2023-2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 145,345, ЕБС-д суралцаж буй 771,722 СӨБ суралцаж буй 274,236, НТБТ-д суралцаж буй 5,095 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөгчдийн мэдээллээр лавлагааны сан баяжиж, 449,747	100%	70%

				E-Mongolia системийн санд орсон байна.		иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна. Багшийн эрүүл мэндийг хамгаалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 2024 оноос төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд байгаа багшийн мэдээллийг ашиглан өмчийн эзэн ялгахгүй, бүх шатлал эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлсэн багшид хувийн даатгалын байгууллагаас хөнгөлөлт, урамшуулал авах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ үүссэн. Иймд БШУЯ-наас ЦХХЯ, ЭМЯ, E-Монголиа ТӨҮГ-тай хамтран ажиллаж, Засгийн газрын 2022 оны 196 дугаар	
--	--	--	--	--	--	--	--

							<p>тогтоолоор батлагдсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын дагуу эрүүл мэндийн даатгал хийж буй даатгалын компаниуд Цахим хөгжил харилцаа холбооны яамтай гэрээ байгуулснаар Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээс дээрх хоёр сервисээр багш эрүүл мэндийн ямар үйлчилгээ авсан талаарх мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн.</p>		
1.4.2	Цахим технологид тулгуурласан бүртгэл, мэдээллийн санг ашиглан тусгай зөвшөөрөл олгоно.	-	БШУ-ны салбарын цахим хэлбэрээр олгодог болсон тусгай зөвшөөрлийн тоо.	И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1. дүгээр зүйлийн 7 дугаарт заасан БШУЯ-ны олгох	БШУЯ-ны олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх	БШУ-ны салбарт тусгай болон энгийн зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх	БШУЯ-аас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1-7.4, 7.10-7.12, 8.20-8.23, 8.2 дугаар зүйлийн 6.2-6.5, 6.14-д заасан энгийн болон тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт	90%	90%

				зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.		ирүүлсэн аж ахуй, нэгж байгууллагын ирүүлсэн баримт бичигт холбогдох хууль журмын шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгаж, шаардлага хангасан хуулийн этгээдэд холбогдох 11 төрлийн тусгай болон 5 төрлийн энгийн зөвшөөрлийг олгож байна. МУ-ын Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын дагуу И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран ЗТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 7.1-7.4, 7.10-7.12 тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, 2024 онд нэмэлтээр ЗТХ-ийн 8 дугаар бүлгийн 8.2 дугаар зүйлийн 6.3-6.4, 6.13-т заасан энгийн зөвшөөрлийг цахимуулж, зөвшөөрлийн хүсэлтийг https://license.mn		
--	--	--	--	---	--	--	--	--

						<p>системээр хүлээн авч шийдвэрлэх ажлыг эхлүүлсэн. Мөн ГТСМТ төвтэй хамтран аймаг, нийслэлийн засаг дарга нар олгодог цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрөл, БШУЯ-наас олгодог дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг цахимжуулж license.mn-д нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, 2025 оноос хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. ЗТХ-ийн 8.20-8.23-т заасан цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрлийг нэгдсэн системд нэвтрүүлэхэд нэмэлт хөгжүүлэлт шаардлагатай байгаа тул 2024 ондоо багтаан нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хагас жилийн</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						хугацаанд www.license.mn тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан нийт 27 байгууллагын тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичигт магадлан шалгах ажиллагааг хийж, 19 байгууллагад зөвшөөрөл олгосон байна. 1 байгууллагад тусгай зөвшөөрөл олгох боломжгүй болохыг системээр дамжуулан мэдэгдсэн.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Салбарын статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, тайлагнах, түгээх, үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, хэрэгжилтэд мэргэжил, арга	-	Салбарын статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, тайлагнах, түгээх, үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах	Боловсролын болон шинжлэх ухааны салбарын албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулан үр дүнг батлагдсан	Боловсролын болон шинжлэх ухааны салбарын 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулан үр дүнг батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх бөгөөд 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан тархаасан байна	Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн 2023- 2024 оны хичээлийн жилийн эмхэтгэлийн нийт 165 хуудас тайланг сүүлийн 4 жилийн динамик мэдээллээр баяжуулан боловсруулж, үр дүнгийн тайланд	90%	100 %

	зүйн дэмжлэг үзүүлэх			хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж байна. Мөн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан олон нийтэд тархаж байна.			БШУЯ-ны газар хэлтсүүдээс санал авч тусгаж ажилласан. Тус тайланг нийт 7 бүлгийн хүрээнд 2500 орчим үзүүлэлтээр баяжуулан боловсруулж гаргасан.		
3.1.1	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	-	Албан ёсны статистикийн мэдээний тоо	Боловсролын салбарын 2023-2024 оны албан ёсны статистикийн мэдээг нэгтгэн хянаж, боловсруулаад батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж, нийтэд тархаасан.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулсан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2023-2024 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлтийн А-ТМБ-14, А-ТМБ-15, 2023 оны орлого, зарлага, хөрөнгийн А-ТМБ-16, А-ТМБ-16.1, А-ТМБ-16.2 маягтын мэдээллийг БШУЯ-аас 1/952 тоот албан бичгээр болон цахимаар ҮСХ-д хүргүүлсэн. БШУЯ-ны цахим хуудсанд 05 дугаар сард байршуулан нийтэд тархаасан. СӨБ-ын дэвшилт, төгсөлтийн	90%	70%

							<p>бүртгэлийг 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс системд нээж аймаг дүүргийн мэргэжилтнүүдэд чиглүүлэх сургалтыг цахимаар хийж, мэдээлэл хүргэн ажиллаж байгаа ба 2024-06-01-ний өдрийн байдлаар цэцэрлэгийн дэвшилт, төгсөлтийн бүртгэл 100 хувь хийгдсэн. Ерөнхий боловсролын хувьд ЕБС-ийн төгсөлтийн мэдээний шинэчилсэн маягтын хөгжүүлэлтийг туршиж, нэгжид гаргасан. Үүний дагуу Нийслэл болон аймгуудад нэгдсэн зааварчилгаа чиглэл хүргүүлэх албан мэйл явуулсан ба аймаг, нийслэлийн БШУГ-ууд болон ЕБС-иудаас системд улсын шалгалт болон анги дэвших</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						<p>шалгалтын дүн шивэх эрх нээхтэй холбогдон нэгжийн түвшинд тухайн өдөр бүрд дүнгээ баталгаажуулж нэгжийн түвшинд ачаалал үүсгэхгүй байхад анхаарах тухай арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дээд боловсролын 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөгчдийн албан ёсны статистикийн мэдээний бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор БШУ-ны сайдын 2024 оны А/143 тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын төсгөлтийн журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой системээр төгсөлт хийх, лавлагааны санд оруулах алхамчилсан зөвлөмжийг БМТТ, БЕГ болон дээд боловсролын</p>	
--	--	--	--	--	--	--	--

							сургалтын байгууллагуудад хүргүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/71 дугаар тушаалаар батлагдсан Шинжлэх ухаан технологийн салбарын захиргааны 10 маягтаар тус салбарын хүний нөөц, үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг нийт 63 байгууллагаас хүлээн авч боловсруулан албан ёсны статистикийн мэдээллийн А-ШУТ-1-А-ШУТ-8 маягтад нэгтгэн ҮСХ-нд 11/989 тоот албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлсэн.		
3.1.2	Боловсрол, шинжлэх	40 сая төгрөг	Боловсруулж,	2023 онд Боловсрол,	Боловсрол, шинжлэх	Боловсрол, шинжлэх	Боловсрол, шинжлэх ухааны	100%	100%

	<p>ухааны салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна.</p>		<p>хэвлүүлсэн эмхэтгэл</p>	<p>шинжлэх ухааны салбарын 2022-2023 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийг хэвлүүлж нийтийн хүртээл болгосон.</p>	<p>ухааны салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийн эх загварыг бэлтгэн, англи, монгол хэл дээр боловсруулан бэлтгэсэн байна.</p>	<p>ухааны салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан тархаасан байна.</p>	<p>салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийн эх загварыг бэлтгэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Монголын Багш нарын 8 дугаар их хурал"-ийг угтан хэвлүүлснээрээ онцлог ажил болсон. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Зардал батлах тухай" А/72, 194 тоот тушаалын хүрээнд "Боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл"-ийг монгол, англи хэл дээр боловсруулан хэвлүүлж, "Монголын Багш нарын 8 дугаар их хурал"-д хүндэт төлөөлөгчөөр уригдсан 21 аймаг,</p>		
--	---	--	----------------------------	---	--	---	--	--	--

						<p>9 дүүргээс сонгогдсон 1200 багшид тараасан. Мөн эмхэтгэлийн эцсийн үр дүнгийн тайланг УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, бодлогын зарим яамдууд болон бусад бодлого боловсруулагчид, хэрэглэгчдэд тархааж, яамны албан ёсны цахим хаягт байршуулан нээлттэй мэдээлэл авах боломжоор ханган ажилласан. Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн 2023-2024 оны хичээлийн жилийн эмхэтгэлийн нийт 165 хуудас тайланг сүүлийн 4 жилийн динамик мэдээллээр баяжуулан боловсруулж, үр дүнгийн тайланд БШУЯ-ны газар хэлтсүүдээс санал авч тусгаж ажилласан. Тус тайланг нийт 7</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						<p>бүлгийн хүрээнд 2500 орчим үзүүлэлтээр баяжуулан боловсруулж гаргасан. Бүлэг бүрт салбарын үндсэн үзүүлэлтүүдийг сүүлийн 4 жилийн динамикаар баяжуулан аназик хийж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн дүн шинжилгээ хийж, цаашдын төлөв байдлыг 2030 он хүртэлх динамикаар тооцоолон тайланд тусгасан. 2022-2023 оны хичээлийн жилийн статистикийн тайланг боловсруулахдаа хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг хүргэх зорилгоор инфографикаар дүрсэлсэн, мөн салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдийг</p>	
--	--	--	--	--	--	--	--

							тооцон оруулж өгснөөрөө онцлог болсон. Хавсралт: 2 файл		
3.1.3	Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээ болон мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, багц сургалт зохион байгуулна.	50.0 сая.төг	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	2023 оны 08 сарын 23-24-ний өдрүүдэд 21 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн нийт 64 мэргэжилтэнд статистикийн мэдээллийн чанар, хугацааны талаар мэдээлэл хүргэх сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн 2023 оны 06 дугаар сарын 09-16-ны өдрүүдэд сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүд	Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургалтын төлөвлөгөөг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургалтын төлөвлөгөөг батлуулах зорилгоор Дээд боловсролын сургалтын байгууллагын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдтэй 2024 оны 05 сарын 21-22-ны өдөр цахим уулзалт хийж, судалгаа авч, сургалтын агуулгыг боловсруулан ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг	70%	50%

				ийг чадавхжуулах ойнлайн уулзалт, сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.			чадавхжуулах сургалтыг 2024 оны 8 дугаар сарын 25- ны өдрийн дотор хийхээр төлөвлөж байна. Мөн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистикийн мэдээ, тайлан, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 8 дугаар зохион байгуулахаар төлөвлөж байна.		
--	--	--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)